

Материал 1 Барилгын салбарт гарсан осол аваар

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зарласан бүх салбарт болон барилгын салбарт гарсан осол аваарын байдал дараах байдалтай байна.


Уг үйлдвэрлэлийн ослын нөхцөл байдал нь гадаад ажилчдыг оруулаад бүх ажилчдыг тооцсон.

Осол аваарын нөхцөл байдал бол 4 хоногоос дээш амарсан осол аваарын талаар үйлдвэрийн осол аваарын тайлангаас тооцож, амь нас эрсдсэн ослын нөцөл байдал бол амь нас эрсдсэн тайлангаас тооцсон.

		❶事故の型別死傷災害発生状況（平成30年）																				㉖合計	
		⑥墜落・転落	⑦転倒	⑧激突	⑨飛来・落下	⑩崩壊・倒壊	⑪激突され	⑫はさまれ・巻き込まれ	⑬切れ・こすれ	⑭踏抜き	⑮おぼれ	⑯高温・低温物との接触	⑰有害物との接触	⑲感電	⑲爆発	⑳破裂	㉑火災	㉒交通事故（道路）	㉓動作の反動・無理な動作	㉔その他	㉕分類不能	㉖合計	
①全産業		21,221	31,833	6,354	6,410	2,312	5,373	14,585	7,878	258	46	3,546	537	126	64	44	85	7,889	98	16,958	1,445	267	127,329
②建設業		5,154	1,616	636	1,432	489	832	1,731	1,267	103	15	340	91	47	7	8	36	598	8	875	77	12	15,374
③土木工事		889	445	181	406	163	335	615	278	10	8	91	18	3	2	4	3	178	2	231	24	3	3,889
④建築工事		3,313	865	345	756	237	355	771	814	77	2	162	49	17	3	2	22	259	4	459	34	8	8,554
⑤他の建設		952	306	110	270	89	142	345	175	16	5	87	24	27	2	2	11	161	2	185	19	1	2,931


		❷事故の型別死亡災害発生状況（平成30年）																				㉖合計	
		⑥墜落・転落	⑦転倒	⑧激突	⑨飛来・落下	⑩崩壊・倒壊	⑪激突され	⑫はさまれ・巻き込まれ	⑬切れ・こすれ	⑭踏抜き	⑮おぼれ	⑯高温・低温物との接触	⑰有害物との接触	⑲感電	⑲爆発	⑳破裂	㉑火災	㉒交通事故（道路）	㉓動作の反動・無理な動作	㉔その他	㉕分類不能	㉖合計	
①全産業		256	28	3	53	54	58	113	5	0	35	36	17	13	7	1	6	175	3	0	43	3	909
②建設業		136	6	1	24	23	18	30	3	0	13	11	1	5	1	0	2	31	0	0	3	1	309
③土木工事		30	3	1	10	11	13	18	3	0	7	1	0	0	0	0	0	11	0	0	2	1	111
④建築工事		84	1	0	11	8	2	9	0	0	1	8	0	2	0	0	0	12	0	0	1	0	139
⑤他の建設		22	2	0	3	4	3	3	0	0	5	2	1	3	1	0	2	8	0	0	0	0	59

③業種別死傷災害発生状況（平成30年）



- ②8製造業
- ⑩建設業
- ③2陸上貨物運送事業
- ④林業
- ⑩第三次産業
- ⑨鉱業
- ③1交通運輸事業
- ③3港湾運送業
- ⑤農業、畜産・水産業

④建設業における事故の型別死傷災害発生状況（平成30年）



- ⑥墜落・転落
- ⑨飛来・落下
- ⑫はさまれ・巻き込まれ
- ⑮おぼれ
- ⑯感電
- ㉑火災
- ㉔動作の反動・無理な動作
- ⑦転倒
- ⑩崩壊・倒壊
- ⑬切れ・こすれ
- ⑯高温・低温物との接触
- ⑯爆発
- ㉒交通事故（道路）
- ㉕その他
- ⑧激突
- ⑪激突され
- ⑭踏抜き
- ⑰有害物との接触
- ㉐破裂
- ㉓交通事故（その他）
- ㉖分類不能

①事故の型別死傷災害発生状況（平成 30 年）

Ослын төрлөөр ялгасан осол аваарын үүссэн нөхцөл байдал (2018 он)

②事故の型別死亡災害発生状況（平成 30 年）

Ослын төрлөөр ялгасан амь нас эрсдсэн осол аваар үүссэн нөхцөл байдал (2018 он)

③業種別死傷災害発生状況（平成 30 年）

Аж үйлдвэрлэлийн чиглэлээр ялгасан осол аваарын үүссэн нөхцөл байдал(2018 он)

④建設業における事故の型別死傷災害発生状況（平成 30 年）

Барилгын салбар дахь ослын төрлөөр ялгасан осол аваарын үүссэн нөхцөл байдал (2018 он)

①全産業

Бүх үйлдвэрлэлийн салбар

②建設業

Барилгын салбар

③土木工事

Зам гүүр инженерчлэл

④建築工事

Барилгын ажил

⑤その他の建設

Бусад барилгын ажил

⑥墜落・転落

Өндөрөөс унах

⑦転倒

Унах

⑧激突

Мөргөлдөх

⑨飛来・落下

Нисэж унах

⑩崩壊・倒壊

Нурах

⑪激突され

Мөргүүлэх

⑫はざまれ・巻き込まれ

Хавчигдах орооцолдох

⑬切れ・こすれ

Зүсэх, шалбалах

⑭踏抜き

Аюултай зүйл дээр гишгэх

⑮おぼれ

Живэх

⑯高温・低温物との接触

Халуун хүйтэн зүйлд хүрэх

⑰有害物との接触

Хортой зүйлд хүрэх

⑱感電

Тогонд цохиулах

⑲爆発

Дэлбэрэлт

⑳破裂

Хаграх

㉑火災

Галын осол

㉒交通事故(道路)

Зам тээврийн осол(зам)

㉓交通事故(その他)

Зам тээврийн осол(бусад)

㉔動作の反動・無理な動作

Хариу үйлдэл, боломжгүй үйлдэл

㉕その他

Бусад

㉖分類不能

Ялгах боломжгүй

㉗合計

Нийт

㉘製造業

Үйлдвэрлэл

㉙鉱業

Уул уурхай

㉚建設業

Барилга

㉛交通運送事業

Тээвэр

③2陸上貨物運送事業

Хуурай газрын тээвэр

③3港湾運送業

Усан тээвэр

③4林業

Ой мод

③5農業、畜産・水産業

Газар тарийлан, мал аж ахуй, загасны аж ахуй

③6第三次產業

Гуравдагч үйлдвэрлэл

Материал 2 Гадаадын дадлагажигч нарт гарсан осол аваарын бодит жишээ

Ангилал	Осол аваарын бодит жишээ	
Өндөрөөс унах	Жишээ 1	Барилгын шатан дээрх ажлын үед чиглэлээ өөрчлөх гээд хийгүйгэж унасан.
	Жишээ 2	Шилжих хөдөлгөөн хийх үед хөндлөн баганаас барилгын шатны сууринд хөлөө тавихдаа халтирч унасан.
	Жишээ 3	Өмнөх өдөр бороотой байснаас нойтон болж шатаар буух үед халтирч унасан
	Жишээ 4	Кранаар хоолой өргөх үед ачаа бутарч, уя тасарч, хоолой барилгын шатан дээр унасанаас үүдэн барилгын шатан дээр байсан хүн унасан.
	Жишээ 5	Агуулахын дээврийн шиферийг зайлцуулах ажил хийхээр аюулгүйн бүсний гогцоог гол уяанд гогдох үед хөлний суурьшифер хагарч унасан.
	Жишээ 6	Дээвэр будах үед плита норсон байсан тул халтирч унасан.
	Жишээ 7	Суурьлуулах ажлын явцад тогтоогоогүй зүйлээс барих үед мултарч унасан.
Унах	Жишээ 8	Ачааны машинаас ачаа буулгаж зөөх үед зөөж байсан материалаас болж хөлөн хэсэг харагдаагүйгээс хөлд байсан материалд бүдэрч гэмтсэн.
Нурах	Жишээ 9	Малтлагын гадаргуу дээр бууж гар ухлага хийж шалгах үед ар талаас нуралт үүсч бэртсэн.
Мөргүүлэх	Жишээ 10	Барилгын шатыг буулгаж хураах үед, өөр нэг ажилтангийн салгасан төмөрийг доороос нь авах үед гарнаасаа алдаж төмөр хоолой унах үедээ хөл дээр бууж бэртсэн.
	Жишээ 11	Ачааны машинд ачаа ачих үед явган зорчигч ойр байсан тул техник явах хэсэгт очоод хөлөө дайруулж бэртсэн.
	Жишээ 12	Малтлагын үед экскаваторын операторт харагдахааргүй газар байснаас экскаватор эргэх үед шанаганд цохиулж бэртсэн.
Хавчигдах орооцолдох	Жишээ 13	Дугуй хөрөө ашиглан хавтан зүсэх үед хөрөөний дээд хэсэгийг дарж байсан зүүн гарын ажлын бээлийг эргэх хэсэгт ороогдож чигчий хуруугаа бэртээсэн.

Зүсэх шалбалах	Жишээ 14	Хадаас хадагчаар хавтанг тогтоох үед үйлдлээ андуурч өөрийн өвгийг андуурч буудан гэмтээсэн
	Жишээ 15	Гар бөөрөнхий хөрөөгөөр таслах ажил хийж байх үед гар халтирч ирэнд нь хүрч гэмтсэн.
Эвгүй зүйл дээр гишгэх	Жишээ 16	Модны булангаас дээшээ харж илүү гарсан хадаасыг гишгэж, хадаас гутлын ул нэвтлэн хөлөө хатгаж гэмтээсэн.
Хортой зүйлд хүрэх	Жишээ 17	Цахилгаан багаж хэрэглэхийн тулд бензин генератор ашиглах үед ажлын байранд хийн газ дүүрсэн байсан тул дотор муухайрч хийнд хордсон.
	Жишээ 18	Урт түрийтэй гутал өмсөж бетон шахаад гардаг илүүдэл бетоныг цэвэрлэх үед өмсөж байсан өмдөнд дуссан хэсэг улайсан тул эмчид үзүүлсэн.
Хариу үйлдэл, боломжгүй үйлдэл	Жишээ 19	Барилгын шатны хэсгүүдийг ачих явцад тонгойж барилгын шатны хавтанг өргөх үед нуруунд өвдөлт мэдрэгдэж нурууны гэмтэлтэй болсон.

Гадаад ажилчдын ажил мэргэжлийн осол аваар гарсан байдлын өөрчлөлт



(Эх сурвалж : Эрүүл мэнд хөдөлмөр халамжын яам
ГАжилчдын осол гэмтэл өвчний талаарх тайлан.)

○単位：人

Нэгж : хүн

○休業4日以上の死傷者数

4 хоногоос дээш амарсан гэмтэж бэртсэн хүний тоо

Ур чадварын дадлагажигч та бүхэнд дагаж мөрдүүлэх **үндсэн зүйлүүд**

- Очсон ажлын байраны журам (дүрэм)-ыг дагаж мөрдөх.
- Ажлын зааварчилгааг мөрдөх. Зааварчилгааг ойлгохгүй тохиолдолд ахин асууж шалгах.
- Ганцаараа аль болох ажил хийхгүй байх. Айль болох хажуудаа бусад ажилтан байх нөхцөлд ажлаа хийх.
- Унах аюултай газарлуу ойртохгүй байх.
- Түр зуурин зүйлийг налахгүй байх.
- Өргөгдөж байгаа зүйлийн доор орохгүй байх.
- Ажлын явцад өөр тийшээ харахгүй байх.
- Ажлын байрлуу явах үед эргэн тойрноо харж хөдлөх.
- Цахилгаан багаж бол хэрэглээгүй, цэвэрлэгээ хийх үедээ заавал унтраах.
- Хэрэглэхгүй багаж хэрэгсэлийг цэгцэлэх.
- Эвдэрсэн багаж хэрэглэхгүй, сольж өгөхийг хүсэх.
- Тоног төхөөрөмж ажиллуулах зэрэг үед ур чадварын дадлага болон тусгай сургалт аваагүй тохиолдол, тухайн төхөөрөмж ашигласан ажил хийхгүй байх.
- Биеийн байдал муу, санаа зовсон зүйл байгаа тохиолдолд ур чадварын дадлагыг хариуцагч болон удирдагч, амьдралын зөвлөгчтэй зөвлөх.
- Ажлын явцад үүссэн осол аваар бол тухайн үедээ мэдүүлэх.
- Ажлын байрны осол аваараас үүдэлтэй эмчилгээний зардал хэрэгтэй тохиолдолд ажлын ослын даатгалаар эмнэлэгийн эмчилгээний зардал төлөгддөг.

- Ажлын байрны осол аваараас үүдэн ажлаа амрах тохиолдолд 3 хоног дадлага хэрэгжүүлэгч нөхөж, 4 дахи хоногоос ажлын ослын даатгалаас амралтыг нөхөн төлнө.

Материал 4

【4 – 1】Өндрөөс унах

Бороо орж хөл орчим нойтон байснаас халтирч унах

- Аюулгүй ажиллагааны арга хэмжээний асуудал

- Хөл хэсгийн ажлын шал пийр байгаагүй.
- Их хэмжээний бороо зэрэг тэнгэр муу эсвэл барилгын шат угсрах, өөрчилсөний дараах шалгалт хангалтгүй байсан.

- Дадлага хэрэгжүүлэгчийн арга хэмжээ

- Барилгын шат унаж нурахаас сэргийлэх арга хэмжээ авах.(доод пийр, өргөн мод, бариул байршуулах, аюулгүйн бүсийг заавал хэрэглүүлэх)
- Их хэмжээний бороо зэрэг тэнгэр муу эсвэл барилгын шат угсрах, өөрчилсөний дараах шалгалтыг унахаас сэргийлэх тоног төхөөрмж баталгаатай байршсаныг шалгах.




- Ур чадварын дадлагажигч та бүхэн ялангуяа анхаарах зүйл

- Ажлын байр гадаа орчинд учраас бороонд норж, салхинд түгжээ нь мултарч, янз бүрийн нөхцөл байдал байна. Ялангуяа өндөр газар болон нарийн шовх юмний дэргэд унавал том осол болдог. Маш анхааралтай байгаарай.
- Өндөр газэр шилжиж хөдлөх үедээ аль болох боломжоорoo аюулгүйн бүсийг хэрэглэх.
- Бариул байхгүй газарлуу ойртохгүй байх.
- Ажлын байрны шалны онгорхой хэсэгт анхаарах.

【4-2】Өндрөөс унах

Шефирэн дээврийн засварын ажлыг хийхийн тулд дээвэр дээр гарсан үед шефир хагарч унасан.

- Аюулгүй ажиллагааны арга хэмжээний асуудал
 - Аюултай зүйл дээр гишгэх аюултай дээвэр дээр гарах.
 - 30 см өргөн явах хавтан байршуулж, хамгаалас олс байгаагүй.
- Дадлага хэрэгжүүлэгчийн авах арга хэмжээ
 - Аюулгүй байдлын арга хэмжээг авах хүртэл аюултай зүйл дээр гишгэх аюултай дээвэр дээр гаргахгүй байх.
 - 30 см дээш өргөн явах хавтан байршуулж, хамгаалах олс байлгах.



- Ур чадварын дадлагажигч та бүхэн ялангуяа анхаарах зүйл

- Шефир болон шилний таазан дээр бол хархад аюулгүй юм шиг харагдах боловч биеийн жингээр унах аюултай. Ийм осол ихээр гарч байна. Ажил хийх үедээ заавал гишгэх хавтан байршуулж, үүнээс илүү эсвэл бусад хэсгээр явахгүй байх зэрэг ажлын зааврыг дагаж мөрдөх.
- Дээврийн хавтангийн дээр ч гэсэн амархан халтирдаг учраас анхаарах.

【4-3】 Нисэж унах

Кранаар Н хэлбэрийн төмөр материал өргөж, ачааны машинд тавих ажл хийх үед өргөсөн ачааны олс тасарч, ачаа унаж даруулах дөхсөн.

- Аюулгүй ажиллагааны арга хэмжээний асуудал

- Олсны аюулгүй байдлыг шалгаагүй.
- Өргөсөн ачааны доор хэсэгт нэвтэрсэн.

- Дадлага хэрэгжүүлэгчийн авах арга хэмжээ

- Олс тасарч гэмтсэн хэсэг байгаа үгүйг ажил хийхийн өмнө шалгаж, эхэвийн ашиглах болох эсэхийг хангалттай шалгаж ашиглах. Гэмтэлтэй байвал ашиглах боломжгүй болгох арга хэмжээ авах.
- Дэгээдэх ажлыг ур чадвараас нь хамаарч тусгай сургалт болон ур чадварын сургалт дүүргэсэн ажилтнаар хэрэгжүүлэх.
- Өргөсөн ачааны жингийн дээд хэмжээг холбогдох хүмүүст нарийвчлан мэдээллэх.
- Ачаа өргөх ажлын явцад өргөсөн ажаа унах онхолдох аюултай бүсэд хүн ойртуулахгүй байх.



- Ур чадварын дадлагажигч та бүхэн ялангуяа анхаарах зүйл

- Гэмтэлтэй олс хэрэглэхгүй, ачааны доор ойртохгүй байх

【4-4】Хавчигдах

Хүнд машин механизмийн хэрэгслийг солих үед хэрэгсэл хөдөлж цилиндрт хуруу хавчуулагдсан.

- Аюулгүй ажиллагааны арга хэмжээний асуудал
 - Хэрэгслийг хөдөлгөөнгүй суурьлуулж байршуулаагүй байсан.
- Дадлага хэрэгжүүлэгчийн авах арга хэмжээ
 - Хэрэгслийг солих ажил (суурьлуулах, салгах)-ийг хийхэд, хэрэгсэл нь уг явцад хөдөлгөөнгүй байлгах үүднээс, солих тавцан хэрэглэх, хавтгай талбайд ажиллах зэрэг тогтвортой бус байдлаар ажлыг хийхгүй байх.



- Ур чадварын дадлагажигч та бүхэн ялангуяа анхаарах зүйл

- Ажлын горимыг дагаж мөрдөх

【4-5】 Мөргүүлэх

Нэвтрэх үед экскаваторын операторт харагдахгүй хэсэгт байсан тул ухрах үед гинжинд мөргүүлсэн.

- Аюулгүй ажиллагааны арга хэмжээний асуудал
 - Экскаваторийн ажлын бүсэд нэвтрэхгүй байх хэсэг тодорхойгүй, чиглүүлэгчийн байрлалаас болж экскаваторийн чишглүүлэлт хийгдээгүй.
- Дадлага хэрэгжүүлэгчийн авах арга хэмжээ
 - Ажиллаж байгаа экскаваторт ойртуулахгүйн тулд хамгаалалтын хашаа болон олс зэргээр ойртох бүсийг тодорхойлох. Бас чиглүүлэгчийг байрлуулах.
 - Экскаваторийн жолооч эргэн тойрноо хангалттай шалгаад жолоодох.
 - Явган зорчигч хөдөлж байгаа экскаваторт ойртохгүй байх.




- Ур чадварын дадлагажигч та бүхэн ялангуяа анхаарах зүйл

- Барилгын төхөөрөмж явах болон эргэх хөдлөх бүсийг шалгах.
- Орохыг хориглосон газар орохгүй байх.
- Чиглүүлэгчийг дагах.

【4-6】Халуурах шинж тэмдэг

Ажлын өдрийн өглөө биеийн байдал тааруу, зуны халуунд зам засварын ажлын үед ухаан алдсан.

- Аюулгүй ажиллагааны арга хэмжээний асуудал
 - Тохирсон амрах цаггүй, бас шингэн, давс хангалттай аваагүй байсан.
- Арга хэмжээ
 - Ажил эхлэх өдрийн цаг агаарыг шалгах, бас ажилчдын эрүүл мэндийг шалгах.
 - Өдрийн цагаар ажлын цагийг багасгах гэх мэт ажлын цагийг боловсруулах.
 - Сүүдэрлэж, тохиромжтой завсарлага авч, шингэн, давс уух.



- Ур чадварын дадлагажигч та бүхэн ялангуяа анхаарах зүйл

- Биеийн байдал муу үед хэтрүүлэлгүй заавал мэдэгдэх.